



ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
ЯАМНЫ АВТОТЭЭВРИЙН
БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ
ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН ДАРГА
..... С.БАТБОЛД

БАТЛАВ:

ШУТИС-ИЙН МЕХАНИК ТЭЭВРИЙН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ

..... Д.ЦОЛМОНБААТАР



"МОНГОЛ ИНЖЕНЕР 2019" СЭДЭВТ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ,
СУРГАЛТ, БҮТЭЭЛИЙН ҮЗЭСГЭЛЭН ЗОХИОН БАЙГУУЛАХ
АЖЛЫН УДИРДАМЖ

2019.01.03.

Ерөнхий зохион байгуулагч:

- Монгол Улсын Зам тээвэр хөгжлийн яам
- ШУТИС, Механик тээврийн сургууль

Зорилго:

Профессор, багш, судлаач, инженер, техникийн ажилтнуудын судалгааны ажлын үр дүнг түгээн дэлгэрүүлэх, үйлдвэрлэлд нэвтрүүлэх, бизнесийн байгууллага, их, дээд сургуулиудын хамтын ажиллагааг сайжруулах, сайн туршлага, мэдлэгийг харилцан солилцох, хамтарсан төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, инженерийн зохион бүтээх ажил, инновацийн бүтээл, инженерчлэлийн оновчтой шийдлийг дэмжихэд чиглэгдсэн эрдэм шинжилгээний хурал, бүтээлийн үзэсгэлэн, сургалтыг зохион байгуулах үндсэн зорилготой.

Хамрах хүрээ:

Инженерийн чиглэлээр сургалтын үйл ажиллагаа явуулдаг их, дээд сургуулийн профессор багш нар, төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжүүдийн инженер, техникийн ажилтнууд, судлаач, судлаач-оюутан нарын дунд зохион байгуулагдана.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

"МОНГОЛ ИНЖЕНЕР 2019" сэдвийн хүрээнд "Материалын хэмнэлттэй төхөөрөмж, Эрчим хүчний хэмнэлттэй төхөөрөмж, 3D хэвлэх төхөөрөмж, Тээвэр, Логистик менежмент, Металлурги, Ногоон технологи" чиглэлээр дараах ажлуудыг зохион байгуулна. Үүнд:

➤ **Эрдэм шинжилгээний хурал:** Инженер, техникийн ажилтнууд, багш, судлаач оюутан нарын дунд зохиогдох "МОНГОЛ ИНЖЕНЕР 2019" сэдвээр хурлыг зохион байгуулна.

➤ **Сургалт:** Инженер техникийн ажилтнуудад зориулсан CAE/CAM, Автомашины цахилгаан ба электрон систем, Хий, шингэн, цахилгаан систем, Үйлдвэрлэлийн автоматжуулалтын үндэс-микро-электроникийн төхөөрөмж, түүний програмын удирдлагын чиглэлээр сургалтыг зохион байгуулна.

➤ **Бүтээлийн үзэсгэлэн:** Багш, судлаач, инженер, техникийн ажилтнуудын инновацийн бүтээлээр үзэсгэлэн гаргаж, шилдэг бүтээлүүдийг шалгаруулна.

Оролцогчдод тавигдах шаардлага:

Оролцогчид насны хязгаарлалт тавигдахгүй ба илгээх илтгэл нь судалгаа шинжилгээний ажлын шаардлагыг хангасан, тодорхой үр дүн гаргаж боловсруулалт хийгдсэн байх ба бүтээл нь инноваци, шинэлэг шийдлийг тусгасан байна.

Өгүүлэл, постерийн стандарт нь ШУТИС-ийн эрдэм шинжилгээний өгүүлэлд тавигдах шаардлагыг хангасан байна.

Мэдээллийг хүлээн авах:

Оролцох бүртгэл, судлаачийн мэдүүлгийг www.mongol-engineer.mn веб сайтаар **2018.12.10 - 2019.02.10** хооронд авна.

Албан бичиг, хүсэлтийг (эрдэм шинжилгээний хуралд оролцох чиглэл, бүтээлийн талаар; хамрагдах хүсэлтэй сургалтын төрөл, сэдэв, бүрэлдэхүүний талаар; үзэсгэлэнд тавигдах бүтээлийн талаар г.м...) электрон хувилбараар mongolengineer@must.edu.mn цахим хаягаар хүлээн авна.

Сургалтын хураамж:

- САЕ/САМ-ын сургалт [16 цаг] – 200.000 төгрөг;
- Автомашины цахилгаан ба электрон системийн сургалт [16 цаг] – 200.000 төгрөг;
- Хий, шингэн, цахилгаан системийн сургалт [16 цаг] – 200.000 төгрөг;
- Үйлдвэрлэлийн автоматжуулалтын үндэс – микро-электроникийн төхөөрөмж, түүний програмын удирдлага [16 цаг] – 200.000 төгрөг;

Сургалтын хөтөлбөр, агуулгын талаарх дэлгэрэнгүй мэдээлэлийг www.mongol-engineer.mn хуудаснаас авна уу.

Зохион байгуулагдах газар, хугацаа:

*Хаяг: Улаанбаатар хот, Хан –Уул дүүрэг,
Энхтайваны өргөн чөлөө, Энгельсийн гудамж,
Механик Тээврийн сургууль*

Хугацаа: 2019 оны 1-4 дүгээр сарын хооронд

Огноо	Арга хэмжээ	Тайлбар
2019.02.14, 15 Пүрэв, Баасан гариг	Бүтээлийн үзэсгэлэн, эрдэм шинжилгээний хурал	
2019 оны 3-4-р сард ШУТИС.МехТС 7-лаб № 407/110	САЕ/САМ-ынмодуль сургалтууд	Баасан гаригт - 8 цаг Бямба гаригт - 8 цаг
2019 оны 3-4-р сард ШУТИС.МехТС 7-лаб №206	Автомашины цахилгаан ба электрон системийн сургалт	Баасан гаригт - 8 цаг Бямба гаригт - 8 цаг
2019 оны 3-4-р сард	Хий, шингэн, цахилгаан системийн	Баасан гаригт - 8 цаг

ШУТИС.МехТС 7-лаб №110	сургалт	Бямба гаригт - 8 цаг
2019 оны 3-4-р сард ШУТИС.МехТС 7-лаб №221	Үйлдвэрлэлийн автоматжуулалтын үндэс - микро-электроникийн төхөөрөмж, түүний програмын удирдлага	Баасан гаригт - 8 цаг Бямба гаригт - 8 цаг

Шагнал, урамшуулал:

Илтгэл – өгүүлэл	ИТА, Багш
1-р байр	диплом, мөнгөн шагнал
2-р байр	диплом, мөнгөн шагнал
Тусгай байр	диплом, мөнгөн шагнал

Бүтээл	Бүтээл
1-р байр	диплом, мөнгөн шагнал
2-р байр	диплом, мөнгөн шагнал
Тусгай байр	диплом, мөнгөн шагнал

Холбоо барих

Цахим хуудас: www.mongol-engineer.mn

Facebook хаяг: Монгол Инженер 2019


Цахим хаяг: mongolengineer@must.edu.mn

Эрдэм шинжилгээний хуралтай холбоотой мэдээллийг purevd@must.edu.mn цахим шуудангаар /утас: 94045440/ хандаж авна уу.

Сургалттай холбоотой мэдээлэлийг tsooj@must.edu.mn цахим шуудангаар /утас: 99244776/ хандаж авна уу.

Бүтээлийн үзэсгэлэнтэй холбоотой мэдээллийг ya.renchinvanjil@must.edu.mn цахим шуудангаар /утас: 99044522/ хандаж авна уу.

ХЯНАСАН:

ШУТИС, Механик тээврийн сургуулийн
эрдэмтэн нарийн бичгийн дарга  Н.Пүрэвдорж

БОЛОВСРУУЛСАН:

ШУТИС, Механик тээврийн сургуулийн
ахлах багш  Ш.Цоож

АТБХЗГ-ын ахлах мэргэжилтэн  Ц.Баяржаргал